



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 522

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3, 6.2.4, 6.2.5, 6.4.3, 6.3.5, 6.4.5, 6.4.6, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Өвөрхангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 нэрийн, нийт 7,749,083.41 (долоон сая долоон зуун дөчин өсөн мянга наян гурван төгрөг дөчин нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Өвөрхангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Лхам-Оролмаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Барилга буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын мэдэлд хэвээр үлдээж зориулалтаар нь ашиглах, нөхөн сэргээх;

2.4.Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Дуланж

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 12
дугаар сарын 02-ны өдрийн 572
дугаар тогтоолын хавсралт

"Өвөрхангай-АЗЗА" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
данснаас хасах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	УАЗ-452 маркийн пургон автомашин, 40-65 ӨВА улсын дугаартай, арлын дугаар-37410020125485	2002	1	6,768,100.00	6,768,100.00
2	Битумын агуулах	1985	1	553,037.63	553,037.63
3	Мазутын барилга	1985	1	427,945.78	427,945.78
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН			3 (гурав)	7,749,083.41 (долоон сая долоон зуун дөчин есэн мянга наян гурван төгрөг дөчин нэгэн мөнгө)